



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/44

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Турк улсад эмчлүүлэхэд санхүүгийн дэмжлэг хүссэн Мөрөн сумын иргэн М.Ням-Оргилд (Хүү Б.Батжаргал 1 нас 3 сартай Өнчин тархины саажилт, булчингийн сулрал оноштой) 1,000.000 төгрөг, санхүүгийн дэмжлэг хүссэн өвлийн хүйтэнд гэр нь шатсан Тосонцэнгэл сумын иргэн Н.Даваахүрэлд 1,000.000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 2,000.000 (Хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН